



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 53

Арвайхээр

“Сум хөгжүүлэх сан”-гийн үйл ажиллагаанд
хяналт тавих орон тооны бус зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 153 дугаар 2016 оны тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 3.3.2 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн ахлагч: Д.Сосорбарам /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч/

Гишүүдэд: Д.Төмөрбат 1 дүгээр багийн иргэн
Б.Гэрэлмөнх 2 дугаар багийн иргэн
Х.Жавзмаа 3 дугаар багийн иргэн
Ц.Сосорбурам 4 дүгээр багийн иргэн
Д.Алтанцэцэг 5 дугаар багийн иргэн
Б.Лхамаа 6 дугаар багийн иргэн
Ч.Энхтуяа 7 дугаар багийн иргэн
С.Долгорсүрэн 8 дугаар багийн иргэн
Д.Батцэрэн 11 дүгээр багийн иргэн
М.Төрболд /Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны төлөөлөл/

2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэнд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа хяналт шалгалт хийж, дүнг тухай бүр Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Сосорбарам/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН

D:\2017on\Albanbichig\Togtool

13 00179